

## ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛЫГ ЭРЧИМТЭЙ ХӨГЖҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

**Л.ЧУЛУУНБААТАР**

*Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим  
chuluunbaatar13@yahoo.com*

*Түлхүүр үг: Хавсрага ухаан, оюунлаг, шалтгаал, магадлалт*

**Өгүүллийн товч агуулга:** Энэ өгүүлэлд түүхийн шинжлэх ухааны судалгааг түүхэн хүн судлалын чиг хандлагатай болгохын ач холбогдлыг товч тодорхойлж, оюунлаг (ментальность), шалтгаал (детерминизм), санамсаргүй ба магадлалт хүчин зүйлсийн талаар зарим баримт жишээн дээр тулгуурлан авч үзэв. Түүхэн хүн судлалыг эрчимтэй хөгжүүлснээр монголын түүхийн өнөө хэр тайлагдаагүй нууцаас үнэн зөв тайлбарлаж дүгнэлт гаргах боломж олдоно гэж үзлээ. Түүхийн энэ хавсрага ухааныг эрчимтэй хөгжүүлэхэд эрдэмтэд судлаачид хамтран ажиллах, гадаадын судлаачдаас сурах зүйл чухал үүрэгтэй билээ.

Орчин үеийн түргэн хурдацтай хөгжил нь шинжлэх ухаан технологийн асар өөрчлөлтийг улам гүнзгийрүүлж, чанарын цоо шинэ шатанд хүргэж байгаагийн зэрэгцээ шинэ, шинэ бодит шаардлагыг бий болгож байна. Энэ нь түүх, нийгмийн ухааны судалгаа, сургалтанд ч нэгэн адил хамаарч байгаа билээ. Гэвч манай нийгмийн ухааны салбарын хөгжилт дэлхийн жишгээс хоцорч байна уу, эсвэл өрөөсгөл хандлагатай юм уу гэх зэрэг олон асуудал зүй ёсоор анхаарал татаж байна. Молхи миний бодоход, манай оронд хуучин социалист үзэл суртал, нэг онол, сэтгэлгээний хомсдолоос болж түүхийн ухааны ажил их хоцрогдож байсан бол өнөө үед хэлний бэрхшээл, ном мэдээллийн дутагдалтай байдлаас шалтгаалж урагшаа олигтой ахиж чадахгүй байна уу гэж үзүүштэй. Энд хамгийн гол нь хувь хүний идэвхи санаачлага, уйгагүй зүтгэл чармайлт нэн чухал юм. Энэ бүхнийг үл нуршин, шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгааг өргөжүүлэх чиглэлээр түүхэн хүн судлал (историческая антропология)-ыг түлхүү анхаарч, судалгааны үр дүнг ашиглах тухайд зарим нэг санаа бодлоо илэрхийлэхийг гол зорилт болголоо.

Түүхийн шинжлэх ухааны судалгааг орчин үеийн онол, арга зүйн шинэ шатанд хөгжүүлэхэд салбар болон хавсрага ухааны үүрэг онцгой ач холбогдолтой билээ. Ялангуяа түүхэн хүн судлал (историческая антропология), түүхэн сэтгэл судлал (историческая психология) зэрэг шинжлэх ухааны судалгааны ололтыг бүтээлчээр

ашиглах үндсэн дээр шинэлэг арга зүйг удирдлага болгох нь хөгжлийн бодит шаардлагад бүрэн нийцэж буй ирээдүйтэй чиг хандлага болж байна. Гэвч түүхийн салбар болон хавсрага ухаан манай улсад сүүлийн үед хөгжиж байгаа туршлага төдий л хангалттай биш юм. Энэ нөхцөлд манай эрдэмтэд судлаачид дэлхийн нэртэй эрдэмтдийн судалгааны үр дүнгээс санаа сургамж авах, өөрийн өвөрмөц онцлогтой холбож уламжлал, шинэчлэлийн үүднээс асуудлыг бодитой авч үзэх боломжтой ажээ. Өнөөгийн бодит байдлыг иш үндэс болгож хавсрага ухааны судалгааг өргөжүүлж, түүний үр дүнг улам өндөржүүлэх хэрэгтэй байна.

Өрнөдийн эрдэмтэн А.Я.Гуревич түүхийн шинжлэх ухааныг түүхэн хүн судлалын хандлагатай болгож, түүхийн судалгаанд түүхэн процессын субъектив, сэтгэл судлалын талыг чухалчлан “оюунлаг” /ментальность/ гэх ойлголтыг дэвшүүлэн тавьжээ. “Оюунлаг” гэх ойлголт нь аль нэг нийгмийн, нэг соёлд хамаарагдах хүмүүс өөрийн байгалийн ба нийгмийн хүрээлэл, өөрсдөө өөрсдийгөө өөрийнхөөрөө үзэх, ухамсарлах болгодог тухайлсан ерөнхий “ухааны багаж”, “сэтгэл судлалын хэрэглэл”-тэй байхыг хэлнэ. Хүний эмх цэгцгүй, янз янзын хүртэмж, сэтгэгдэл нь түүний ухамсарт боловсрогдон ертөнцийн аль нэг талаар цэгцэлсэн зураглал болж, ертөнцийг үзэх энэ үзэл нь хүний аливаа авирт арилшгүй хэв буй болгоно. Түүхэн процессын субъектив (санааны) тал, уг нийгмийн ба соёлын нийтлэгийн шинж болсон сэтгэхүйн ба мэдрэмжийн арга нь тэдний түүхийн процесст шингэн орно (Гуревич 1988: 56-57) гэж А.Я.Гуревич бичсэн байна. Энэ нь К.Марксын бичсэнчлэн ”Түүх бол өөрийн зорилготой хүний үйл ажиллагаанаас өөр юм огт бус” (Маркс, Энгельс 1956: 102) гэдгийг нотолж бүхий юм. Тэгэхээр Хүннүгийн Модун шаньюй, их эзэн богд Чингис хоёр нийгмийн хөгжлийн өөр, өөр түвшинд өсөж, амьдралын хүнд бэрх замыг туулсан ч ерөнхий “ухаан багаж”, сэтгэл зүйн тал нь жирийн иргэдээс огт өөр, илүү дайчин, илүү өндөр түвшинд байжээ гэж хэлж болмоор билээ. Энэ нь тэдний сургаалиас тодорхой харагдаж байна.

Модун шаньюй “газар бол улсын үндэс” гэсэн бол Чингис хаан ”алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдартугай” гэж сургажээ. Тухайн үеийн монгол дахь орчин нөхцөл нь тэдэнд асар их үүрэг хариуцлага ноогдуулж байсан гэж үзэлтэй. Нүүдэлчдийн анхны төр улсыг байгуулах үед Модунд шандаст сайн хүлэг морь, хайртай хатнаас нь илүүтэй газар нутаг чухал байсан. Тэгвэл Чингис хаан бол тархай бутархай олон ханлиг, аймгуудыг нэгтгэхэд өөрийн амь биеийг үл хайрлан, ухаан бодол, ур чадвараа хөвчлөн шаргуу тэмцэж ялалт амжилтанд хүрснээр Их

Монгол улсыг байгуулсан билээ. Модун шаньюй, Чингис хаан нар нь монголын түүхийн бүтээгдэхүүн, оюунлаг сайтай, эрчимт хүмүүс байжээ.

Монголын эртний түүхийг түүхэн хүн судлалын хандлагын үүднээс судлаагүй болохоор хүннүгийн Модун шаньюй, Чингис хаан хоёр бодол, сэтгэл, мэдрэмж зэргээрээ нэг үеийн хүмүүс шиг дүрслэгдэж байна (Сүхбаатар 1992: 217-218 ) гэж нэрт эрдэмтэн Г.Сүхбаатар асаны бичсэнтэй санал нэг байна. Бас сайхь эрдэмтэн “түүх бол амьд хүмүүсийн үйл ажиллагааны нөлөөгөөр нөлөөлөгдсөн систем нийлбэр мөн” гэж олонтаа ярьж байсныг дурсан санаж, түүхэн хүн судлалыг эрчимтэй хөгжүүлэхийг уриалж байжээ гэж бодогддог.

Түүхийн шинжлэх ухааны ашиг сонирхолд антропологийн судалгааны үр дүнг ашиглах зорилгыг түүхэн хүн судлал тавьдаг (Алексеев: 50). Учир нь антропологийн шинжлэх ухааны судалгааны зарим арга нь биологийн болон статистик тооцоонд (биометр) тулгуурласан, бодит биет олдвор дээр хэмжилт хийж, тэндээс дүгнэлт гаргасан байдаг. Энэ талаараа археологийн болон палеонтологийн судалгаатай ижил төстэй хэдий ч хүний тухай судалгаа учраас бүр ч нарийн ээдрээтэй болов уу гэж бодогддог. Түүхэн хүн судлалд асуудлыг “түүхийн өргөн фон дээр” (Алексеев: 63) авч үзэх шаардлага тавигддаг байна. Уг шаардлага нь монголын түүхийн тодорхой үе шат, нөхцөл байдал, бодит нөлөөллийг илүүтэй харгалзан үзэж, түүхэн бие хүний хувийн онцлог, сэтгэл зүй, зан төлөвийн шинж чанарыг боломжийн хэрээр тодорхойлох ёстойг харуулж байгаа бололтой. Бас монгол хүний бие бялдаын өсөлт хөгжилт, хоол унд, хувцас хунар, орон сууцны онцлогийг бусад ард түмнүүдтэй харьцуулж дүгнэлт хийх нь зөвхөн эрдэм шинжилгээ танин мэдэхүйн төдийгүй, практик ач холбогдолтой ажээ. Энэ талаар монгол орноор аялсан гадаадын жуулчид, судлаачдын тэмдэглэл, ялангуяа Плато Карпини, Вильгельм Рубрук, Марко Поло нарын бүтээлүүд сурвалжийн шинж чанартай гэж хэлж болохоор юм. Тэдний бичсэнээр, монголчууд бол хацар шанаа өргөн, онигор нүдтэй, жижгэвтэр намхан хамартай, өтгөн хамсөг, урт сормуустай, багавтар сахалтай, хөрслөг хүрэн бор царайтай хүмүүс ажээ (Марко Поло 1956; Рубрук 1988; Карпини 1988). Мөн армяны сурвалжуудад монголчуудын тухай бичихдээ: “Тэд өргөн мөртэй, булчинлаг гартай, том толгойтой, гөлгөр, сэгсгэр үстэй, жийтгэр нүдтэй, зузаан уруултай, навтгар хамартай, шингэн сахалтай байсан” (Галстян 1960: 5 Яблонский 1986: 7 дам ишилснээр) гэжээ. Ер нь XIII зууны үеийн монголчуудыг бие бялдар өсгөлүүн, эрүүл чийрэг, ид хавтай байсан учраас ертөнцийн талыг байлдан дагуулж сүр хүчээ илэрхийлж ирсэн гэдэг дүгнэлт бий. Энэ дүгнэлтийг түүхэн хүн судлалын судалгаан дээр тулгуурлаж хийсэн үү, тэгвэл он цаг улиран өнгөрөх тутам

хүний яс чанар суларч бие организмын болон сэтгэл оюуны хувьд ядуурч доройтсон уу гэсэн асуудал зүй ёсоор анхаарал татаж байна. Хүмүүсийн ярианд ч ийм үг, үнэлэлт гарч байдаг нь санамсаргүй хэрэг биш. Уг асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн бодит хариуг түүхэн хүн судлалыг эрчимтэй хөгжүүлснээр өгч чадах билээ. Тиймээс түүхэн хүн судлалыг түлхүү хөгжүүлэх нь зөвхөн монгол хүний өсөлт хөгжилтийг тодорхойлох төдий биш, монгол овог аймгууд, угсаатан ястны өвөрмөц онцлогийг ойлгож, судалгааг улам гүнзгийрүүлэх нэг бодит боломж олгоно гэдэгт эргэлзэхгүй байна.

Түүхэн хүн судлалыг өргөжүүлэн хөгжүүлснээр монгол ба монгол бус овог, аймаг, бүлэг, бүлэглэлүүдийн харилцан үйлчилсэн, нөлөөлсөн, түлхэц үзүүлсэн онцлог, сэтгэл зүйн нарийн учир холбогдлыг ихээхэн тодорхой мэдэж болох үндэстэй юм. Энэ нь монгол нутагт мандаж байсан улс үндэстнүүдийн хөгжлийн өнөө хэр тайлагдаагүй нууцаас үнэн зөв тайлбарлаж дүгнэлт гаргах боломж олгоно гэж үзүүштэй. Одоогоор монголын овог, ханлиг аймгуудын тухай тун ерөнхий бичиж, бүдэгхэн төсөөлж байна. Энэ нь манай оронд түүхийн салбар болон хавсрага ухаанууд үүсч хөгжөөд төдий л удаагүй, туршлага сургамж их хуримтлуулж амжаагүйтэй холбоотой. Тухайлбал, Монголчуудын угсаа гарвалын тухайд 1980-1990-ээд онд судалгаа өргөжиж шинэлэг үнэлэлт хийгдэж, зөвхөн гадаадын эрдэмтдийн саналыг үг дуугүй хүлээн зөвшөөрч явахаа больсон (Батсуурь 1988; Спицына и др. 1995; Викторова 1980; Дэлгэржаргал 2005: 144) гэж хэлж болохоор байна.

МЭӨ II мянганы дунд үеэс Монгол нутагт оршин байсан нүүдэлчдийн дунд угсаа – соёлын бүслэл тогтож, Баруун болон Төв Монголд хиригсүүрийн соёлт овог аймгууд, Төв болон Дорнод Монголд дөрвөлжин булшны соёлт аймгууд зэрэгцэн оршиж, улмаар миграцийн улмаас холилдон бие биедээ аж ахуй, соёл, хүн ам зүйн хувьд уусан угсаатан бүрэлдэх үйл явцад ихээхэн нөлөөлөлцжээ. Хүннү нарын антропологи хэв шинж бүрэлдэх үйл явцад Дорнод Монголын хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёлт хүн ам, Баруун Монголын хиригсүүр буюу чулуун овоот булшны соёлт хүн ам гол цөм нь болсон гэж үзэж болох юм. Харьцуулсан судалгаанаас үзэхэд орчин үеийн монголчууд нь Төв Монголын хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёл, хүннү, дундад зууны түрүү үе, Монголын үеийн хүн амтай угсаа гарвалын нягт холбоотой болох нь харагдаж байна (Түмэн ба бусад 2002: 51) гэсэн дүгнэлт байдаг. Энэ нь монголчуудын генийн сангийн голомт Хүннү улсын нутаг дэвсгэр, түүний улс төрийн төвтэй яв цав давхцаж байгаа нь монгол угсаатны бүрэлдэх үйл явц Хүннүгээс өвлөн ирсэн гэж доктор Ж.Батсуурь дүгнэхэд хүргэжээ. Түүхэн хүн судлалын судалгааг

эрчимжүүлснээр монгол хүн, овог аймаг, угсаатан ястны талаар илүү тодорхой, үнэн бодитой үнэлэлт дүгнэлт хийх боломж олгох бөгөөд энэ нь монголын түүхийн судалгааг дэлхийн түвшинд гаргах, хүлээн зөвшөөрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Манай залуу эрдэмтэд, судлаачдын өмнө шинжлэх ухааны гэрэлт ирээдүй байгаа учраас онол, үзэл баримтлал, арга зүйн чамбай бэлтгэлтэй байж олон орны их мэргэдтэй хүч оюунаа сорих өргөн боломж байна.

Хүн бол гол үйлчлэгч, түүхийн субъект, зохиож хийсэн бүх хэрэгслийг бүтээгч мөн гэдэг утгаараа тэр нь “бүх юмсын хэмжээс” болж байдаг. Хүн бол танин мэдэхүйн ба үйл ажиллагааны идэвхитэй субъект учраас ертөнцийг өөрчлөн хувиргаж, космогенный, техногенный болон антропогенный иргэншилд (мэдээллийн) гол үүрэг гүйцэтгэсээр байна. Энэ бүхнийг антропологи шалтгаалцлын (детерминизм) үүднээс ерөнхийд нь дүгнэж үзэх нь өнөө үеийнхэнд төдийгүй, ойрын ирээдүйд онцгой ач холбогдолтой билээ.

Хүн бол өөртөө тохирсон үзэл бодлын үүднээс ертөнцийг харах хараатай. Аливаа хүн алсыг харсан, өөрийн гэсэн үзэл бодолтой байх нь эрх чөлөөний бодит илрэл, гол үр дүн юм. Түүхэн хүн судлалд “хүний үйл ажиллагааг оюун ухаан, хүсэл зориг, соёл, зан суртахуун, сонголтын эрх чөлөө, хөдөлмөрийн үйл ажиллагаа зэрэг тодорхой шинжүүдтэй нь холбоотойгоор авч үздэг учраас байгаль, техник, хүмүүнлэгийн ухааны салбарын судалгааны үр дүнд тулгуурладаг” (Содномгомбо, Дарьхүү 2004: 215-216). Хамгийн гол нь хүний оюун ухаан, үйл ажиллагааг түүхэн тодорхой үеийн түвшинд бодит нөхцөл байдал, нөлөөлөлтөй нягт холбоотой авч үздэг болохоор шинжлэх ухааны олон төрөл, чиглэлийн судалгааг онцгой анхаарч, антропологи детерминизмийн зарчмууд, зүй тогтлыг удирдлага болгосноороо хүмүүсийн олон янз үйлдлүүдийн магадлалт өндөр болдог байна. “Оюуны үйл явцын хөгжилд санамсаргүй ба магадлалт хүчин зүйлс их ач холбогдолтой, тусгай, давтагдашгүй үзэгдлүүд оролцдог, зөвхөн ололт биш, харин нөхөгдөшгүй алдагдал хохирол ч байдаг. Энэ бүхэн антропологи детерминизмийн онцлог, иргэншлийн үйл явцын хөгжилд түүний онцгой ач холбогдлыг тодорхойлж байна” (Содномгомбо, Дарьхүү 2004: 218).

Сүүлийн жилүүдэд монголын түүхийн судалгаа үлэмж гүнзгийрч олон чухал бүтээлүүд хэвлэгдэн гарч байна. Манай эрдэмтэд судлаачид монголын түүхийн бүх үед холбогдох олон асуудлыг сурвалж, судалгааны хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан судалж,

## ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ

өөрсдийн санаа бодлоо оновчтой илэрхийлж иржээ. Ер нь манай эрдэмтэд судлаачид үндэсний хүрээнд чамлалтгүй бүтээл тууривал гаргасан боловч дэлхий дахинд тэр бүрийг хүртээл болгох, сурталчилах тухайд тийм ч далайцтай биш гэж боддог. Энэ талаар олон шалтгааныг дурдаж болох байх, хамгийн гол нь манайхны судалгаа олон улсын түвшинд хүрээгүй, тэдэнд танигдаагүйтэй холбоотой болов уу. Бас түүхэн хүн судлал, түүхэн утга зүйн ухаан, угсаатны сэтгэл судлалын хэл шинжлэл зэрэг түүхийн салбар болон хавсрага ухааны судалгааны үр дүнг сайн ашиглаж чадаагүйтэй холбогдож байна. Зөвхөн нэг баримт дурдахад, Хүннү улс нь анх 24 аймгийн холбоон дээр байгуулагдсан гэхэд тэдгээрийн овог, аймаг тус бүр өөр, өөрийн нэр, өвөрмөц онцлогтойг судлаачид тэр бүр тодорхой гаргасангүй, ихээхэн ерөнхий бичсээр иржээ. Мөн түүхт хүмүүсийн тухай судалгаанд ч анхаарах зүйл их байдаг. Түүхэн хүн судлалын судалгааны үр дүнг сайтар нягтлаагүйн улмаас “амьд” хүмүүсийн түүх тодорхой харагдахгүй байна. Ийм учраас түүхэн хүн судлалыг эрчимтэй хөгжүүлж судалгааны үр дүнг сайн ашиглах нь чухал юм.

### ДҮГНЭЛТ

Монгол улсын түүх, нийгмийн шинжлэх ухааны хөгжил дэлхийн түвшинд харахан хүрээгүй, манай эрдэмтэд судлаачдын тухай олон улсын хэмжээнд сайн мэдэхгүй байна. Энэ нь бид бүхэн хэлний бэлтгэл, ном, мэдээллийн хомсдолтой талаас шалтгаалж өөрсдийнхөө судалгааг дэлхий дахинд сайн сурталчилж чадаагүйтэй холбоотой. Бас түүхийн салбар болон хавсрага ухаан ч сайн хөгжөөгүй байна. Түүхэн хүн судлалаар мэргэшсэн хүн, хэвлэгдсэн бүтээл эрээд олсонгүй. Энэ баримт бүхнийг нотолж бүхий мэт.

Ер нь “XVIII зууны II хагасаас эхлэн хүн судлалын шинжлэх ухаан биеэ даасан салбар болон хөгжиж ирсэн. Антропологийн шинжлэх ухаан нь хүн төрөлхтний гарал үүсэл, төрхтний онцлог, хүний биеийн өвөрмөц шинж, тэдгээрийн ялгаануудыг судлах ухаан билээ (Наран 2001: 9,121). Түүхийн шинжлэх ухаан, ялангуяа монголын түүхийн ухааныг түүхэн хүн судлалын хандлагатай болгоход юуны өмнө түүхэн үйл явцын субъектив, сэтгэл судлалын талыг голлож оюунлагийг тодорхойлох, “амьд” хүмүүсийн түүхийг өгүүлэх, хүмүүсийн олон янз үйлдлүүдийн үнэн бодит магадлалыг өндөр түвшинд хүргэх, антропологи детерминизмийн зарчмууд, зүй тогтлыг хэлбэрэлтгүй мөрдөх нь зүйтэй байна.

Манай оронд түүхэн хүн судлалыг эрчимтэй хөгжүүлэх нь онол, үзэл баримтлал, арга зүйн төдийгүй практик ач холбогдолтой, их ирээдүйтэй юм. Юуны өмнө монголын

